



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.04.18 № 4-А/2168
танай _____-ны № _____-т

2017 оны төсвийн тодотгол
хүргүүлэх тухай

ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиуд болон дагалдах хууль, Улсын Их Хурлын тогтоолууд Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдлаа. Орон нутгийн 2017 оны тодотгосон төсвийн тооцоолол болон орон нутгийн тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчмыг хавсралтаар хүргүүлж байна.

- Хавсралт №1. Орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчим
- Хавсралт №2. Орон нутгийн 2017 оны санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоо
- Хавсралт №3. 2017 оны орон нутгийн төсвийн суурь орлого
- Хавсралт №4. 2017 оны орон нутгийн төсвийн суурь зарлага
- Хавсралт №5. 2017 онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг
- Хавсралт №6. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2017 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал

Орон нутгийн 2017 оны төсвийн тодотголын дэлгэрэнгүй тоо, мэдээллийг Төсвийн ил тод байдлын www.iltod.gov.mn сайтад байршуулсан болно. Монгол Улсын 2017 оны тодотгосон төсвийн дагуу орон нутгийн төсвийн тодотголыг хийж, төсвийн хуваарийг шинэчлэн баталж ирүүлэх, УИХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Төсвийн тухай хуулийн дагуу зохион байгуулахыг хүсье.

Хүндэтгэсэн,



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

01360